

Газар эзэмших гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн 10 /арав/ иргэний газар эзэмших эрхийн хугацааг сунган хавсралтаар баталгаажуулсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2012 оны А/197 дугаар захирамжийн Гомбо Отгонжаргал, 2012 оны А/196 дугаар захирамжийн Гомбо Нямсүрэн, 2012 оны А/186 дугаар захирамжийн Загд Санжаа, 2011 оны А/162 дугаар захирамжийн Лувсанбямба Ганхуяг, 2011 оны А/161 дүгээр захирамжийн Лхагважав Балжинням, Цэдэнбал Наранбаатар, Жаргал Самьяа, 2012 оны А/187 дугаар Батнасан Өнөрзаяа, 2011 оны А/91 дүгээр захирамжийн Доржсүрэн Нарантуяа, 2012 оны А/13 дугаар захирамжийн Дүгэржав Мягмарсүрэн нарт холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрх нь сунгагдсан иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газрын албанд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ